

**Засгийн газрын 2022 оны 92 дугаар  
тогтоолын хавсралт  
ТӨРӨЛ БҮРИЙН ҮҮЛДЭР, ОМГИЙН МАЛЫГ ҮРЖҮҮЛЭХ БҮС,  
БАЙРШЛЫГ ТОГТООХ ЖУРАМ  
Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Монгол Улсад үржүүлж буй төрөл бүрийн үүлдэр, омгийн малын ашиг шимийн чиглэл, цөм сүргийн байршил, үржүүлэх зохистой бүс нутгийг тогтооход энэ журмыг баримтална.

1.2.Энэ журмын зорилго нь Монгол Улсад хянан баталгаажсан уугуул үүлдэр, омог болон гадаадаас авчирч нутагшуулан үржүүлж буй өндөр ашиг шимт малыг дасан зохицсон, ашиг шимээ бүрэн өгөх, хэвийн өсөж үржих боломжтой бүс нутагт нь сонгон үржүүлэх, сайжруулагчаар ашиглах, генетик нөөцийг хадгалж, хамгаалах замаар мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, эдийн засгийн ач холбогдол бүхий мал сүргийг өсгөн үржүүлэх, мал аж ахуйн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэгдэнэ.

1.3.Энэ журам нь Монгол Улсад мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж, ашиг шимийг нь хүртэж буй этгээдэд адил хамаарна.

Хоёр.Хэрэгжилтийг зохион байгуулах

2.1.Төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг тэдгээрийн дасан зохицсон, ашиг шимээ бүрэн өгөх, хэвийн өсөж үржих боломжтой бүс нутгаар нь Монгол Улсад хянан баталгаажсан уугуул үүлдэр, омог болон гадаад улсаас импортолж нутагшуулан үржүүлж буй өндөр ашиг шимт мал гэсэн ангиллаар малын төрөл, үүлдэр, омог тус бүрт тогтооно.

2.2.Төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг тогтоох саналыг тухайн төрлийн үүлдэр, омгийн малын биологийн онцлог, арчилгаа, маллагааны технологи, ашиг шимийн чиглэл, хянан баталгаажуулсан шийдвэр, цөм сүргийн байршил, цаашид үржүүлэх тохиромжтой бүс нутгийн талаар судлаач, зохион бүтээгч, хамтран оролцогчдын хийсэн судалгаа, санал, хүсэлтэд үндэслэн Малын үүлдэр, ашиг шимийн зөвлөл гаргана.

2.3.Малын үүлдэр, ашиг шимийн зөвлөлийн гаргасан саналыг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Малын генетик нөөцийн үндэсний зөвлөлдөх хорооны хуралдаанаар хэлэлцэж, энэ журамд заасан зорилго, ангилал, шаардлагад нийцүүлэн тогтоосон, төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг баталгаажуулах тухай зөвлөмжийг гаргана.

2.4.Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ журмын 2.3-т заасан зөвлөмжийн дагуу төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг тогтоох шийдвэрийг гаргана.

2.5.Монгол Улсад хянан баталгаажсан уугуул үүлдэр, омгийн малын цөм сүргийг үржүүлэх бүс, байршлыг үүлдэр, омгийн тодорхойлолт, зохион бүтээгч, хамтран оролцогчдын санал, үржлийн ажлын стратеги төлөвлөгөөнд тулгуурлан анх өвөрмөц шинж байдлаа олж авсан, хадгалж ирсэн орчин зүйн бүрдэлд буюу уугуул орчинд нь тогтоож хадгалж хамгаална.

2.6. Гадаад улсаас импортолж нутагшуулан үржүүлж буй өндөр ашиг шимт үүлдэр, тэдгээрийг ашиглан гаргаж авсан үржлийн малыг шилжүүлж дасгасан орчин зүйн бүрдэлд буюу нутагшуулан үржүүлэх боломжит бүс, байршилд цэврээр нь сонгон үржүүлэх замаар генетикийн нөөцийг ашиглаж, хадгалж хамгаална.

2.7.Гоо, тархалтын хувьд доройтолд орсон болон арчилгаа маллагааны онцгой нөхцөл шаардах үүлдэр, омгийг анх батлагдсан орчинд нь өсгөж үржүүлэх чиглэлийг баримталж биотехнологийн дэвшилтэт аргыг ашиглан сайжруулах замаар генетик нөөцийг хадгалж хамгаална.

2.8.Судалгаа, шинжилгээ, туршилтын явцад үр дүн нь батлагдаж, шинээр хянан баталгаажсан үүлдэр, омог, өндөр ашиг шимт импортын малын ашиг шимийн чиглэл, онцлогийг харгалзан боломжит бүс, байршилд үржүүлж, генетикийн нөөцийг ашиглаж, хадгалж хамгаална.

2.9.Удам зүйн үнэт чанарын хувьд өвөрмөц, хязгаарлагдмал нөөц, тархалт, ашиглалт бүхий тэмээ, сарлаг, цаа буга зэрэг мал, амьтан түүний төрөл, зүйлийг хамгаалах, зохистой үржүүлэх арга хэмжээг энэ журамд нийцүүлэн орон нутгийн мэргэжлийн байгууллага хэрэгжүүлнэ.

2.10.Үүлдэр, омгийн малыг үржлийн зориулалтаар бойжуулах, худалдан борлуулах, шилжүүлэх үйл ажиллагааг тогтоосон бүс, байршилд нийцүүлэн эрхлэх бөгөөд тухайн мал нь цөм сүргийн стандарт, шаардлагыг бүрэн хангасан, ялган тэмдэглэж бүртгэлжүүлсэн, удам гарвал нь баталгаажсан байна.

2.11.Малын үүлдэрлэг байдал алдагдах, тоо толгой цөөрөх, устаж мөхөх эрсдэлээс сэргийлэх, хамгаалах зорилгоор үүлдэр, омгийн малаас үр авах, дээж, сорьц, цуглуулгыг бий болгох, тусгай орчинд хадгалж, хамгаалах, үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх, үржүүлэгт ашиглах асуудлыг малын үндэсний генийн санг хамгаалах, сайжруулах чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага хэрэгжүүлнэ.

2.12.Энэ журмын хэрэгжилтийг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн бүх шатны мэргэжлийн байгууллага чиг үүргийн хүрээнд хариуцан зохион байгуулна.

Гурав.Хэрэгжилтэд хяналт тавих

3.1.Аймаг, нийслэлд малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сум, дүүрэгт сумын Засаг даргын Тамгын газрын хөдөө аж ахуйн тасаг энэ журмын хэрэгжилтэд технологийн хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

3.2. Журмын хэрэгжилтийг хангуулах, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг хянан шийдвэрлэхтэй холбогдон гарах асуудлыг бүх шатны мэргэжлийн хяналтын байгууллага, мал үржлийн хяналтын улсын байцаагчид холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

-----oOo-----